

ТҮВШИНШИРЭЭ СУМЫН 2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭ

Төрийн удирдлагын чиглэлээр:

Аймгийн Засаг даргын 2022 оны 08 тоот албан даалгаврын хүрээнд мал аж ахуйн салбарын болон төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах сумын Засаг даргын 2022 оны 01 дүгээр даалгаврыг хэрэгжилтийг ханган ажиллаж, хэрэгжилтийг 14 тутамд аймгийн ХХААГ-т хүргүүлэн ажиллаж байна.

2022 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлага 10 дугаар сарын 8-нд зохион байгуулагдаж сумын 30 залуус үзлэгт хамрагдаж 6 залуу цэргийн жинхэнэ албанд татагдлаа.

Сумын эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн судалгааг гаргаж, эрсдэлт нөхцөлд амьдардаг 44 өрхийн 83 хүүхэд судалгаанд бүртгэгдсэн байна. Гэрээр айлчлах аяныг зохион байгуулж 21 өрх 38 хүүхдийн ар гэрээр эргэлт хийсэн.

2022 оны 10 дугаар сарын байдлаар сумын нийт суурин хүн ам 3425, өрх 981, хүн ам, өрхийн мэдээллийн цахим санд хяналт тавьж ажиллаж байна. Шинээр төрсөн 36, нас барсан 17 хүн бүртгэгдсэн.

10 дугаар сарын 8-нд шилэн дансанд байгууллагуудын сарын төсөв гүйцэтгэл, орон нутгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл, ОНХСангийн төлөвлөгөө гүйцэтгэл бусад мэдээ мэдээллийг шивж орууллаа.

Нийгмийн даатгалын НД 8, НД7 тайлангууд мөн татварын ТТ 11, ТТ 12 буюу үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутган тооцсон татварын тайлангуудыг цахим санд оруулсан.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн сарын мэдээ болох Оёдол, Модон эдлэл, Талх нарийн боов үйлдвэрлэл, блок үйлдвэрлэлийн болон байгууллагын дулааны мэдээнүүдийг гарган Статистикийн хэлтэст хүргүүлсэн. Мөн Сүм хийдийн үйл ажиллагааны мэдээ, Мал эмнэлгийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн мэдээ, Төрийн бус байгууллагын улирлын мэдээнүүдийг Статистикийн хэлтэст хүргүүлсэн.

Орон нутгийн ерөнхий орлого, татварын орлогын гүйцэтгэлийн мэдээг шилэн дансанд шивсэн.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Сумын ОНХС-гийн хөрөнгөөр 2022 онд хийгдэх төлөвлөгөөт ажлуудаас сумын төвийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх(20 сая), гудамжны гэрэлтүүлгийн засвар үйлчилгээ(10 сая) ажлууд 100% хийгдээд байна. Хүүхэд залуучуудын спорт тоглоомын талбай (85.0 сая), жишиг багийн төвийн засвар (50.0 сая)-ын ажлуудын

тендерт “Жоди прожект” ХХК шалгарч, гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна. Бохир соруулах автомашин худалдан авах тендерт 3 компани материалаа ирүүлснээс 68,8 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Оточ Оргил” ХХК-г шалгаруулан бараа нийлүүлэх гэрээ байгуулагдаад байна.

Малын тоо толгойн албан татварын орлогоор хийгдэж байгаа бэлчээрт гүн өрмийн худаг гаргах ажлын худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж “Номгон хайрхан Оргил” ХХК 25,0 сая төгрөгийн үнийн санал ирүүлснээр шалгарч, худгийн өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэн, худгийн барилгын ажлыг ЗДТГ өөрсдийн нөөц бололцоогоор хийж гүйцэтгэсэн.

Цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлын тендер зарлагдаад байна.

Шууд худалдан авах ажиллагаагаар хийгдэх ЭМТ-ийн амбулаторийн барилгын дээврийн засварын ажил(17.0 сая) , бэлчээр хамгаалах огтоно устгалын ажил(15.0 сая), ЕБС-ийн үдийн цайны тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх ажил(13.9 сая), Дэлгэрхаан багийн төвийн засварын ажил(10.0 сая), өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажил(17.1 сая), мод суулгац худалдан авах(5,0 сая), ахмадын хөгжлийн төвийн тохижилт(15.0 сая)- ын ажлууд хийгдэж байна.

Сумын төвийн нэгдсэн хогийн цэгийг цэгцлэх ажлын хүрээнд хогийг сар бүр түрж цэгцлэх ажил хуваарийн дагуу хийгдэж байна.

Арабын Эмират улсын иргэнтэй 1 идлэг шонхорын гэрээ байгуулж ажилласан.

10 дугаар сарын 12-22-ны өдрүүдэд “ТЭРБУМ МОД” үндэсний хөтөлбөрийн хүрээнд ойн зурваст бүх төсөвт байгууллагын 120 албан хаагч , хөдөлмөр халамж үйлчилгээний санхүүжилтээр 14 иргэнийг цалинжуулж 10 хоног ажиллуулан нийтдээ 5700 мод суулгасан.

Ногоон ажлын байр хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Засаг даргын тамгын газрын даргаар батлуулан ажиллаж байна.

Сумын ундны усны худаг болох Хүйтэнгийн худгийг лайдаж цэвэрлэх ажилд тамгын газрын хамт олон оролцож засварласан.

Мөн сумын төвийн болон Хүйтэнгийн худгийн ойр орчмын 5 тонн орчим хог хаягдлыг хогийн цэгт төвлөрүүлсэн.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2022 оны 05 сарын 2022/366 тоотын дагуу “ ЯНДАНГАА ХӨӨЛЪЕ-ӨНТЭЙ ӨВӨЛЖЪЕ” аяныг зохион байгуулж ажиллалаа.

Сумын Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 19-ны өдрийн А/75 тоот захирамжаар охин төл малд бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх

вакцинжуулалт хийгдэж дууслаа. Тарилганд 5 ажлын хэсэг гарч 6 малын их эмч 12 туслах ажилтан ажилласан. Тарилганд 5 багийн 580 өрхийн тугал 4231, хурга 49209, ишиг 32262, бүгд 85702 толгой мал хамрагдаж 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Үнэгт багийн нутагт гарсан малын гоц халдварт цэцэг өвчний өвчлөл зогсож 2022 оны 10 дугаар сарын 11-нд хорио цээрийн дэглэм, 10 дугаар сарын 25-нд хязгаарлалтын дэглэм цуцлагдсан. Цэцэг өвчин гарсантай холбогдуулан сумын нийт хонин сүргийг масс вакцинжуулалтад хамруулах ажил 82%-тай хийгдэж байна.

Өлзийт багийн нутаг Төгөл гэх газар гоц халдварт бог малын мялзан өвчин оношлогдож холбогдох хууль журмын дагуу арга хэмжээг авч хорио цээрийн дэглэм тогтоон голомтонд ажиллаж байгаа эмчийг мэдээлэл арга зүйгээр хангаж ариутгал халдваргүйжүүлэлт, үзлэг тандалтыг өдөр болгон хийлгэж өвчилсөн малыг тусгаарлан устгах арга хэмжээг авч ажиллалаа. Нийт өвчилсөн хонь 4, ямаа 7, хурга 23, ишиг 52, нийт 86 толгой малыг устгаж халдваргүйжүүлэлт хийлээ. Голомтын болон сэжигтэй бүсийн 9 өрхийн хонь 4076, ямаа 3231, нийт 7307 толгой малд бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг хийсэн. 2022 оны 10 дугаар сарын 26-нд хорио цээрийн дэглэм цуцлагдаж хязгаарлалтын дэглэмд шилжинэ.

Дорноговь аймгийн Дэлгэрэх суманд үхрийн арьс товруутах өвчин оношлогдсонтой холбогдуулан тус сумтай хил залгаа нутагладаг 15 өрхийн үхрийг уг өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор угааж, вакцинжуулалтад хамрууллаа. Вакцинжуулалтад Өгөөмөр багийн 15 өрхийн үхэр 720, тугал 240, нийт 960 толгой мал хамрагдсан.

Мөн орон нутгийн галзуу, цусан халдварт, томуу, боом, листериоз зэрэг вакцинжуулалт хийгдэж бод 1887, бог 71924, бүгд 73811 толгой хамрагдаж цахим системд шивэгдсэн байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Нийгмийн халамжийн чиглэлээр: Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан /LMIS/-д ажил хайгч 8, шинэ ажлын байр-2 иргэн, түр ажлын зуучлал-15 нийт 25 иргэний мэдээллийг бүртгэсэн.

2022 оны 10-р сард 2020-2021 онд төсөл хөтөлбөрт хамрагдсан хөтөлбөрт хамрагдсан 11 иргэн хуваарийн дагуу 2875900 төвлөрүүлэхээс 6 иргэн 1750000 төгрөгийн ХЭДС-ийн 100120037010 тоот дансанд төвлөрүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарлагдсан "Ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-т 1 иргэний төслийг аймагт хүргүүлсэн.

ХХҮГ, сумын ЗДТГ-тай хамтран "Ногоон ажил" хөтөлбөрийн ажлыг 2022-10-19 ны өдрөөс эхлэн 2022-10-31ны хугацаанд ажлын 10 хоног 15 иргэн ажилласан. Мөн Ногоон ажлын байр хөтөлбөрийн хүрээнд ХХҮГ, сумын ЗДТГ хамтран мод тарих ажлыг хийж нийт давхардсан тоогоор 21өрхийн 40 иргэнд хамрагдаж түр ажлын байраар зуучилсан.

Нийгмийн халамжийн тэтгэвэрийн сунгалт 7 иргэнд, асаргааны тэтгэмж сунгалт-2 иргэнд, 932903 төгрөгийн мэдээллийг "Нөхөн олголтын" жагсаалтаар гарган бэлтгэн өгч нөхөн олгуулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүний эрхийн тухай хуулийн дагуу түлээ нүүрсний хөнгөлөлтөд 22 иргэнд 3080,0 төгрөг, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 9 хүүхдэд 1260,0 төгрөгийн хөнгөлөлт, Ахмад настны тухай хуулийн дагуу ганц бие, үр хүүхэдгүй 4 ахмад настанд амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэрээр 560,0 төгрөг, нийт 35 иргэнд түлш худалдан авах 4,900,000 төгрөгийн хөнгөлөлтөд хамруулсан.

10-р сард Нийгмийн халамжийн ehalamj системд Нийгмийн халамжийн тэтгэвэрийн сунгалт 3 иргэн, асаргааны тэтгэмж 5 иргэнд, Цалинтай ээж хөтөлбөрийн 0-3 хүртэлх насны хүүхэд асарсаны тэтгэмжид 9 иргэнд, Жирэмсэн эхийн тэтгэмжид 7 иргэнд, нийт 21 иргэний мэдээллийг бүртгэж тэтгэвэр тэтгэмжид хамруулсан.

Нийгмийн даатгалын чиглэлээр: Эрүүл мэндийн даатгалд 4 хүний 495600 төгрөг, сайн дурын даатгалд 42 хүний 3366340 төгрөгийн орлого орсон. 10 дугаар сарын тэтгэвэрт 2 банкаар дамжуулан 422 хүнд 205859564 төгрөгийн тэтгэвэр олгосон. Оршуулгын тэтгэмжид 1 хүнд 1000,0 төгрөг олгосон. 1 хүнд 1584507 төгрөгийн жирэмсэн амаржсаны тэтгэмж олгосон. 1 хүнд 68821 төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгосон.

Боловсролын чиглэлээр: ЕБС: Дэлхий багш нарын 28, Монголын багш нарын 56 дахь өдрийн тэмдэглэн өнгөрүүлж, баярын хурал, хүндэтгэлийн тоглолт, шагнал гардуулах үйл ажиллагааг зохион байгууллаа. Дэлхийн охидын өдрийг тэмдэглэн өнгөрүүлж, хөвгүүдийн “Хийморь” клубээс танилцах үдэшлэг, нөлөөлийн сургалт “Open Mic” үйл ажиллагааг зохион байгуулав.

Сургуулийн ахлах ангийн сурагчдын эцэг эхтэй “Асран хамгаалагчдын уулзалт ярилцлага” зохион байгуулж сургуулийн үйл ажиллагааг захирал, сургалтын үйл ажиллагааг сургалтын менежер , хүүхэд хамгааллын талаар нийгмийн ажилтан нар танилцуулж, эцэг эхчүүдээс гаргасан саналыг сонсож харилцан ярилцав.

Сургуулийн аварга шалгаруулах “Үндэсний бөхийн барилдаан”-ыг сургуулиас 8 насны ангиллаар зохион байгууллаа.

Сургуулийн дотуур байрын сурагчдын эцэг эхийн “Асран хамгаалагчдын уулзалт ярилцлага”-ыг зохион байгуулж тэдний санал хүсэлтийг сонслоо.

10 дугаар сарын 3-наас 11-р сарын 3-ныг хүртэлх хугацаанд улсын хэмжээнд зохион байгуулж байгаа “Үе тэнгийн дээрэлхэлтийг таслан зогсооё” сарын аяны хүрээнд хөтөлбөр боловсруулж сурагчдад нөлөөлөх нөлөөллийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж байна.

Зэрэгтэй багшийн манлайлал “Үзүүлэх хичээл” 10-р сарын 24-ний өдрөөс эхлэн явагдаж байна .Үүнд тэргүүлэх болон заах аргач зэрэгтэй 13 багш хамрагдана. Залуу багш нарын заах арга ,ур чадварыг нэмэгдүүлж ажлын байран дээрээ бие биеэсээ харилцан суралцаж хамтран хөгжих ажиллагаа юм.

2023 оны ЭЕШ-д бэлтгэж 12-р ангийн сурагчдаас судалгаа авахад 20 сурагч ЭЕШ өгөхөөс математик-10, Монгол хэл-13, англи хэл-13, Нийгэм судлал-16, Хими-4, биологи-4, физик-5 сурагч саналаа өгч ЭЕШ бэлтгэх буюу сонгон судлах хичээлийг 7 хоногт хичээл бүрт 6 цагаар хичээллэж байна.

Багшийн мэргэжлийн хөгжлийн бүлгийг байгуулж ,сургуулийн багшийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж мөрдөн ажиллаж байна.

10-р ангийн нийт 24 суралцагчид 9 судлагдахуунаар цахим сонгонд хамрагдаж байна. Нийт 40/давхардсан тоогоор/ хүүхэд цахимаар сорил өгсөн. Цахим сургалт ба сонгон судлах хичээл, мэргэжлийн сонголтын тухай ахлах ангийн сурагчдад 2 удаа, эцэг эхчүүдэд 2 удаа сургалтыг зохион байгуулаад байна. Мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөөний дагуу багш, удирдах ажилтан нийт 37 багш, 111 сургалтанд хамрагдахаар “ArLus платформид” бүртгүүлж багш хөгжлийн санхүүжилтээс 4.440.000 төгрөгийг сургалтын төлбөрөө төлөн сургалтанд хамрагдахаар боллоо.

Цэцэрлэг: Багш хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Бүлгийн багш нарын дунд “Сайн багшийн сайн технологи” ур чадварын уралдаан, туслах багш нарын дунд “Шүд” сэдвийн доор ХАБ багтай хамтран үзүүлэх үйл ажиллагаа явуулж шилдэг багш нараа шагнаж урамшууллаа. Үүний үр дүнд багш нар шинэ шинэлэг санаа, оновчтой төлөвлөлт шилдэг аргазүйгээс хамтдаа суралцсан бусдад түгээсэн сайн үйл ажиллагаа болохын зэрэгцээ үзүүлэн 119 ширхэг, тараах материал 275 ширхэгийг хийсэн байна.

Энэ сард хүүхэд рүү чиглэсэн “Эв долоогоор наадацгаая” аяныг эхлүүлэн 7 бүлгийн 225 хүүхэд эв долоо тоглоомтой болоод байна.

Мөн хүүхдийн хөгжлийг дэмжих бусдаас суралцах боломжийг хангах зорилгоор цэцэрлэг дээр 13 төрлийн дугуйланд 225 хүүхдийг хамруулж 18 багш ажилчид удирдан ажиллуулж эхлээд байна.

Байгууллагын соёлыг төлөвшүүлэх ажилчид хамт олон иргэдийн сэтгэл зүйд эерэг нөлөөлөл, хүндлэлийг бий болгож хандлагыг өөрчлөх, албан хаагчдыг ёс зүйг дээдэлсэн өөрийн ажлаар бахархдаг эерэг харилцаа хандлага бүхий ухамсарт зан үйл, соёлд суралцуулах зорилгоор “Таны соёл- бидний соёл” уриан дор “Соёлч хамт олон” сарын аяныг зарлаад хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дотоод хяналтын баг багш ажилчид руу чиглэсэн удирдамжтай хяналт шалгалтыг 2 удаа хийж гарсан алдаа дутагдалыг дор бүр арилгаж зөвлөгөө зөвлөмжийг өгч ажиллаа.

2022-2023 оны хичээлийн жилд “Хүүхэд хамгааллын баг”-ийг засаг даргын тушаалаар 9 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулж төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

8 бүлгийн нийт 256 хүүхдийн эрсдлийн дэлгэрэнгүй судалгааг авч нэгтгэлээ.

Байгууллагын багш ажилчид “Байгууллагын хүүхэд хамгааллын бодлого”, “Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм”-ийг хэлэлцэн батлаж, хүүхэд хамгааллын бодлогыг ханган ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэн ажиллахаа амлаж, гарын үсэг зурж баталгаажууллаа. Мөн “Гараас-Гарт” дүрмийг хэрэгжүүлэх журам, “Хяналтын камер хянах” журмыг батлан баримтлан ажиллаж байна.

“Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын өөрийн үнэлгээний үлгэрчилсэн загвар”-ын дагуу хүүхэд хамгааллын өөрийн үнэлгээг хийж үнэлгээнд үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх ажлаа тодорхойлон ажлын төлөвлөгөөнд тусгалаа.

Байгууллагын “Хүүхэд хамгааллын самбар”-ын мэдээллийг шинэчлэн “Нэгдүгээрт хүүхэд” буланг гаргаж, хүүхдийн тусламжийн 108 утсыг таниулах зорилгоор самбарын хажууд хүүхдэд харагдахуйц, ойлгомжтой байдлаар байршууллаа.

Хүүхдийг эрсдлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн хүчирхийллийн эсрэг 32 ширхэг зөвлөгөө зөвлөмжийг ангийн групп болон, цэцэрлэгийн цахим хуудсаар хүргээд байна.

Сумын ЭМТ-тэй хамтран цэцэрлэгийн нийт хүүхдүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт 142 хамрагдан, 5 хүртэлх настай 105 хүүхэд А витамин уулаа.

Байгууллагын залуучуудын зөвлөлөөс “ БИД ЗАЛУУС” 14 хоногийн аяныг зохион байгууллаа.

Соёл: 10 дугаар сард нийтийг хамарсан соёлын 4 удаагийн арга хэмжээ зохион байгуулагдсан байна.

Нийтийн номын сангуудад хүүхдийн ном зохиолоор номын сан хөрөнгийг баяжуулахад зориулж 500.000 төгрөгийг Соёлын яамны зүгээс шийдвэрлэсний дагуу 52 нэр төрлийн номоор фондны баяжилтыг хийлээ.

10 дугаар сард шинээр бүрдүүлэлт хийсэн ном зохиолыг хүүхэд багачуудад сурталчлах зорилгоор үзэсгэлэнг зохион байгуулж нийт 95 хүүхэд оролцон карт нээлгэн үйлчлүүлээ.

“Сүхбаатарын өнгө” сонины 5 жилийн ойгоо тохиолдуулан зохион байгуулсан “Найргийн орны-Найрагч хүүхдүүд” уран уншлагын наадамын 1-р шатыг зохион байгууллаа. Наадамд нийт 32 хүүхэд оролцлоо.

Соёлын төвийн дэргэдэх 8-н төрлийн дугуйлан цагийн хуваарийн дагуу 134 хүүхдийг хамруулан хичээллэж байна.

Эрүүл мэнд: Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа нь жигд хэвийн явагдаж байна. Амбулаторын нийт үзлэг 376, алсын дуудлага 11, гэрийн дуудлага 6, хэвтэн эмчлүүлэгч 26, хэвтэн эмчлүүлэгч Ковид /Халдвартай бүс/ - хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөн 6.

Сумын ОНХС-гийн хөрөнгө 17,0 сая төгрөгөөр амбулаторийн барилгын дээвэр, цонхны засварын ажил хийгдэж байна.

Сар бүр хийгддэг хүүхдийн товллын вакциныг хийгээд байна. Ковидын ванцинжуулалтанд энэ сард хамрагдсан хүн байхгүй. 5-11 насны хүүхдийн Томуугийн вакцинжуулалт хийж эхлэхэд бэлэн болоод байна. Тухайн сард Лабораторын хийсэн шинжилгээ үйлчилгээ: Сахар – 6, Серологи – 6, Шээс – 14, Цусны бүлэг – 1, Ковид -19 шинжилгээ тус тус хийгдсэн байна.

Тайлан нэгтгэсэн:

Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Ш.Дүүрэнбилэг

Хянасан:

Тамгын газрын дарга

Ц.Ренчинмядаг